



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/6/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: Утас: 70523020 Аудитор: Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр
---	---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Аудитын санал дүгнэлт



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.02.25 № 1/6-166

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ц.БАТСУГИР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХ-ийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг хэрэгжүүлээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлыг онцолсон хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 128 дугаар захирамжаар бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Баян-Өлгий аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарт 620.4 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

442502029

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно" заасантай нийцэхгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах босго үнийн дээд хязгаарыг зөрчиж 29.6 сая төгрөгөөр ИТХ-ын төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэх зорилгоор мөнгөн аяга худалдан авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", МУЗГ-ын 2024 оны 02 дугаар тогтоолоор "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарт заасан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Тус байгууллага нь тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 126.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн ба үүнээс 4.0 сая төгрөгийн эд хөрөнгийг өөрийн үйл ажиллагаанд ашиглахаар болсныг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй, бусдад шилжүүлсэн 122.0 сая төгрөгийн хөрөнгийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан зарчим болон Сангийн Сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 2.3-т "Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгах мэдээлэл нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэх боломжтой байх, шалгах боломжтой байх зэрэг чанарын шинжүүдийг хангана" гэж заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,490,571.43	31,563,160.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,032,999.00	63,802.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,032,999.00	63,802.00
3121	Төгрөг	3,032,999.00	63,802.00
31212	Монгол банкин дахь харилцах	3,032,999.00	63,802.00
33	АВЛАГА	2,706,432.24	184,938.66
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,671,432.24	149,938.66
335	Бусад авлага	35,000.00	35,000.00
3351	Байгууллагаас авах авлага	35,000.00	35,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,751,140.19	31,314,420.19
354	Хангамжийн материал	30,751,140.19	31,314,420.19
35410	Бичиг хэргийн материал	1,955,300.00	2,011,300.00
35420	Аж ахуйн материал	21,532,920.19	22,514,320.19
35430	Сэлбэг хэрэгсэл	6,063,400.00	6,020,600.00
35440	Түлш, шатах тослох материал	1,199,520.00	768,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	54,491,350.05	91,710,052.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	54,491,350.05	91,710,052.46
392	Биет хөрөнгө	54,054,850.45	91,710,052.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	237,000,000.00	257,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(237,000,000.00)	(215,000,000.03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,965,231.00	66,106,424.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,805,379.96)	(29,656,286.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,214,154.68	45,897,567.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,319,155.27)	(32,637,651.97)
393	Биет бус хөрөнгө	436,499.60	-
39301	Програм хангамж	20,781,528.79	20,561,528.79
39302	Хуримтлагдсан элэгдэл	(20,737,528.95)	(20,561,528.79)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,570,000.00	1,120,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,177,500.24)	(1,120,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	90,981,921.48	123,273,213.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	795,122.63	2,786,440.76
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	795,122.63	2,786,440.76
413	Өглөг	795,122.63	2,786,440.76
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	123,822.63	2,786,440.76
4136	Бусад өглөг	671,300.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	671,300.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	90,186,798.85	120,486,772.55
51	Засгийн газрын хувь оролцоо	90,186,798.85	120,486,772.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	68,719,077.67	68,719,077.67
51101	Өмч: - төрийн	68,719,077.67	68,719,077.67
512	Хуримтлагдсан үр дүн	21,117,232.12	51,423,034.70
51210	Өмнөх үеийн үр дүн	21,117,232.12	21,123,061.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	30,299,973.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	350,489.06	344,660.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	90,981,921.48	123,273,213.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,387,717,288.29	2,383,955,657.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	48,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	48,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	48,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	48,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,387,717,288.29	2,335,955,657.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	378,703,000.00	200,000,000.00

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	360,000,000.00	160,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,703,000.00	40,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,009,014,288.29	2,135,955,657.15
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,009,014,288.29	2,135,955,657.15
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,383,985,725.66	2,347,956,110.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,383,985,725.66	2,347,956,110.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,340,498,225.66	2,335,878,770.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,109,882.30	496,319,250.26
210101	Үндсэн цалин	164,360,270.01	256,520,851.09
210102	Нэмэгдэл	86,069,513.05	194,519,438.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,205,075.69	29,557,070.77
210104	Урамшуулал	30,475,023.55	15,721,890.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,043,302.73	60,873,158.90
210201	Тэтгэврийн даатгал	25,312,497.86	41,920,964.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,001,098.82	4,738,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,400,879.03	3,790,394.90
210204	Ажилгүйдлийн даатгал	575,347.21	947,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,753,479.81	9,476,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,734,228.32	45,934,783.00
210401	Бичиг хэрэг	2,498,800.00	2,674,000.00
210402	Тээвэр, шатахуун	34,573,201.57	32,809,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,247,585.25	4,222,180.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,234,641.50	6,085,353.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,771,900.00	16,414,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	490,000.00	-
210604	Урсгал засвар	27,281,900.00	16,414,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,467,870.00	9,697,700.00
210702	Дотоод албан томилолт	15,467,870.00	9,697,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,845,844,844.87	1,647,291,088.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,842,161,904.87	1,642,044,294.10
210803	Даатгалын үйлчилгээ	3,282,940.00	4,556,794.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,526,197.44	59,348,790.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,101,114.49	9,107,721.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,122,941.00	30,299,053.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,302,141.95	19,942,014.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,487,500.00	12,077,340.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,487,500.00	12,077,340.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,487,500.00	12,077,340.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,731,562.63	35,999,546.87
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,699,573.17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	20,000.02
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	5,679,573.15
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(5,699,573.17)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,731,562.63	30,299,973.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,387,717,288.29	2,335,955,657.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,387,717,288.29	2,335,955,657.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	378,703,000.00	200,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	360,000,000.00	160,000,000.00

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,703,000.00	40,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,009,014,288.29	2,135,955,657.15
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,009,014,288.29	2,135,955,657.15
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,379,389,255.29	2,324,064,564.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,379,389,255.29	2,324,064,564.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,335,890,255.29	2,311,808,424.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,345,177.16	492,640,169.41
210101	Үндсэн цалин	163,595,564.87	226,228,711.09
210102	Нэмэгдэл	86,069,513.05	213,431,497.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,205,075.69	29,377,070.77
210104	Урамшуулал	30,475,023.55	23,602,890.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,618,161.48	60,353,800.00
210201	Тэтгэврийн даатгал	27,887,356.61	41,401,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,001,098.82	4,738,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,400,879.03	3,790,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	575,347.21	947,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,753,479.81	9,476,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,895,166.75	45,811,033.00
210401	Бичиг хэрэг	2,748,500.00	2,784,300.00
210402	Тээвэр, шатахуун	32,573,793.00	32,690,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,247,585.25	4,181,380.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,145,288.50	6,011,353.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,310,900.00	15,782,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,519,000.00	176,000.00
210604	Урсгал засвар	31,791,900.00	15,606,050.00
2107	Томилолт, зочны зардал	15,415,870.00	9,697,700.00
210702	Дотоод албан томилолт	15,415,870.00	9,697,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,847,722,170.90	1,646,690,768.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,844,039,230.90	1,641,443,974.10
210803	Даатгалын үйлчилгээ	3,282,940.00	4,556,794.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,582,809.00	40,832,903.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,953,605.00	9,211,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,629,204.00	31,621,603.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,499,000.00	12,256,140.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,464,000.00	12,256,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,464,000.00	12,256,140.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,328,033.00	11,891,093.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН		14,860,290.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		14,860,290.00
2200	Дотоод эх үүсвэрээс		14,860,290.00
222001	Тоног төхөөрөмж		12,160,000.00
223001	Бусад хөрөнгө		2,700,290.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,328,033.00	(2,969,197.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,032,999.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,032,999.00	63,802.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	төгрөгөөр
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,719,077.67	350,489.06	17,385,669.49	86,455,236.22

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-5,782,271.00	-5,782,271.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,719,077.67	350,489.06	11,603,398.49	80,672,965.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	9,513,833.63	9,513,833.63
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,719,077.67	350,489.06	21,117,232.12	90,186,798.85
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	68,719,077.67	350,489.06	21,117,232.12	90,186,798.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,828.88	5,828.88
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,719,077.67	350,489.06	21,123,061.00	90,192,627.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(5,828.88)	-	(5,828.88)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	30,299,973.70	30,299,973.70
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,719,077.67	344,660.18	51,423,034.70	120,486,772.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,137,204,000.00	2,118,984,564.15	18,219,435.85	99.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,137,204,000.00	2,118,984,564.15	18,219,435.85	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,127,274,000.00	2,109,058,424.15	18,215,575.85	99.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,189,900.00	492,640,169.41	2,549,730.59	99.5
210101	Үндсэн цалин	235,089,000.00	226,228,711.09	8,860,288.91	96.2
210102	Нэмэгдэл	206,099,900.00	213,431,497.19	(7,331,597.19)	103.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,616,000.00	29,377,070.77	(1,761,070.77)	106.4
210104	Урамшуулал	26,385,000.00	23,602,890.36	2,782,109.64	89.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,353,800.00	60,353,800.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	41,401,600.00	41,401,600.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,738,100.00	4,738,100.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,790,400.00	3,790,400.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	947,600.00	947,600.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,476,100.00	9,476,100.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,898,000.00	45,811,033.00	86,967.00	99.8
210401	Бичиг хэрэг	2,792,000.00	2,784,300.00	7,700.00	99.7
210402	Тээвэр, шатахуун	32,699,000.00	32,690,000.00	9,000.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,206,000.00	4,181,380.00	24,620.00	99.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	144,000.00	36,000.00	80.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,021,000.00	6,011,353.00	9,647.00	99.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,140,000.00	15,782,050.00	9,357,950.00	62.8

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	7,640,000.00	176,000.00	7,464,000.00	2.3
210604	Урсгал засвар	17,500,000.00	15,606,050.00	1,893,950.00	89.2
2107	Томилолт, зочны зардал	10,000,000.00	9,697,700.00	302,300.00	97.0
210702	Дотоод албан томилолт	10,000,000.00	9,697,700.00	302,300.00	97.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,449,492,000.00	1,443,940,768.10	5,551,231.90	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,444,002,000.00	1,438,693,974.10	5,308,025.90	99.6
210803	Даатгалын үйлчилгээ	4,800,000.00	4,556,794.00	243,206.00	94.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	200,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,200,300.00	40,832,903.64	367,396.36	99.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,211,300.00	9,211,300.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,989,000.00	31,621,603.64	367,396.36	98.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,930,000.00	9,926,140.00	3,860.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,930,000.00	9,926,140.00	3,860.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,930,000.00	9,926,140.00	3,860.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,137,204,000.00	2,135,955,657.15	1,248,342.85	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,137,204,000.00	2,135,955,657.15	1,248,342.85	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	2,137,204,000.00	2,135,955,657.15	1,248,342.85	99.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,032,999.00	(3,032,999.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	63,802.00	(63,802.00)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	200,000,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	200,000,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	200,000,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	200,000,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	200,000,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	200,000,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	200,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	160,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	40,000,000.00	

5.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 60,915.3 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 30,714.9 мянган төгрөгийн 5 алдааг залруулав.

5.1 Залруулга

1. Завсрын аудитаар 7 дугаар сарын цалингийн зардлыг 307.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, жилийн эцэст шатахууны зардалд 810.0 мянган төгрөгийг цалингийн зардалд бүртгэснийг залруулсан

2. Завсрын аудитаар тайлант хугацааны 8.2 сая төгрөгийн шатахуун, 19.1 сая төгрөгийн талоньг няравын тайлангаар зарцуулж тайлагнасан боловч программд зардлыг бүртгээгүй орхигдуулсныг залруулсан.
3. Ээлжийн амралтыг олгохдоо цалингийн тооцоолсон дүнг журналд бүртгэхдээ давхардуулан бүртгэж 2144.3 мянган төгрөгийн өглөг илүү тусгасныг залруулсан.
4. Тус байгууллага нь төрийн санд байрших ахмадын сангийн дансны үлдээдлийг монгол банкны харилцах дансны үлдээдлээр тайлагнасныг залруулсан.
5. Тайлант хугацаанд балансаас балансад шилжүүлсэн 12.9 сая төгрөгийн хөрөнгийн элэгдлийг бодуулсны дараа өмнөх сарын үлдэх өртгөөр данснаас хасч элэгдлийн зардлыг илүү тооцож /-/ дүнгээр илэрхийлсэн байсныг залруулсан.

Аудитаар нийт 620.4 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 620.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 0 төгрөгийн зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

5.2 Албан шаардлага

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах босго үнийн дээд хязгаарыг зөрчиж 29.6 сая төгрөгөөр ИТХ-ын төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэх зорилгоор мөнгөн аяга худалдан авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, МУЗГ-ын 2024 оны 02 дугаар тогтоолоор “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарт заасан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 128 дугаар захирамжаар бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Баян-Өлгий аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарт 620.4 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно” заасантай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Тус байгууллага нь тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 126.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн ба үүнээс 4.0 сая төгрөгийн эд хөрөнгийг өөрийн үйл ажиллагаанд ашиглахаар болсныг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй, бусдад шилжүүлсэн 122.0 сая төгрөгийн хөрөнгийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан зарчим болон Сангийн Сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 2.3-т “Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгах мэдээлэл нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэх боломжтой байх, шалгах боломжтой байх зэрэг чанарын шинжүүдийг хангана” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Хуваарилах зорилгоор эргэлтийн хөрөнгөд орлогод авсан хөрөнгийг тусад нь дансанд бүртгэж хуваарилах, ашиглах зорилгоор худалдан авсан үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг УСНББОУС 17-д заасны дагуу бүртгэлд тусгаж элэгдүүлэх

Дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэх, албан шаардлагын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд ирүүлнэ үү.

6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардалд зөрүүтэй бүртгэсэн	1	1,117.2			1	1,117.2	1	1,117.2	-	-
Шатахууны зардлыг үлдэгдлээр тайлагнасан	1	27,280.5	1	27,280.5			1	27,280.5		
Өглөг илүү бүртгэсэн	1	2,144.3			1	2,144.3	1	2,144.3		
Буруу дансанд бүртгэсэн	1	63.8			1	63.8	1	63.8		
Элэгдлийн зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	109.1			1	109.1	1	109.1		
Дүн	5	30,714.9	1	27,280.5	4	3,434.4	5	30,714.9	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	-					1	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр/)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	1	620.4	-	-	1	620.4	-	-	-
Дүн	1	620.4	-	-	1	620.4	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилтийг хангаагүй	1	-	-	-	1	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-
Нийт дүн	2	620.4	-	-	2	620.4	-	-	-